

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.02.05

НЭГ. ЗОРИЛГО

Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах бичиг баримтыг хамруулсан. Үүнд:
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын биелэлт
- Дорнод аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт
- Дорнод аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө
- Засаг даргын захирамжийн биелэлт
- Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтны шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Аймгийн ИТХ--аас баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилт
- Засаг даргын албан даалгаврын биелэлт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Боловсролын сайд болон Дорнод аймгийн Засаг даргын хооронд 2024 онд орон нутагт БШУ-ны салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээ
- Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр

- Шилэн дансны хөтлөлт

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хяналтад авсан дараах 13 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 101 заалтын 91 нь бүрэн биелэгдсэн буюу 100 хувийн үнэлгээтэй, 6 нь тодорхой үр дүнд хүрсэн, хэрэгжих шат байгаа буюу 70-90 хувийн үнэлгээтэй, 4 нь эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн ба биелэлтийн дүн дунджаар 96.1 хувьтай хэрэгжүүлсэн байна.

№	Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт						
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Биелэлтийн дүн
			100%	90%	70%	50%	30%	0%	Нийт
1	Ерөнхийлөгчийн зарлиг	2	2						100.0
2	МУ-ын ИХурлын тогтоол	2	2						100.0
3	МУ-ын ИХурлын байнгын хорооны тогтоол	8	8						100.0
5	Засгийн газрын тогтоол	3	3						100.0
6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	1		1					90.0
7	Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	14	11	2		1			95.0
8	Дорнод аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө	9	9						100.0
9	Аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө	26	20	2	1		3		90.0
10	Аймгийн ИТХ--аас баталсан хөтөлбөрүүд	3	3						100.0
11	Засаг даргын захирамж	22	22						100.0
12	Засаг даргын албан даалгавар	2	2						90.0
13	Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтны шуурхай хуралдааны тэмдэглэл	9	9						100.0
	БҮГД	101	91	5	1	1	3	0	96.1

- Ерөнхийлөгчийн зарлиг 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилт – 100%
- Улсын Их Хурлын 2 тогтоолын 2 заалтын хэрэгжилт-100%
- Улсын Их Хурлын байнгын хорооны 3 тогтоолын 8 заалтын хэрэгжилт-100%

ХА СУРВАЛЖ. ХАМГААЛ ШИЙЛЖИЛЭЛ, ТӨЛӨӨ ХЭРЭГЖИЛТ ДЭЛХИЙН АЖИЛЛАГААНЫ ТАЛБАР

Эмэйл: muugii75edu@gmail.com Утас: 89336088

- Засгийн газрын 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилт – 100.0%

3.2. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 26 арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газар хяналтад аван хэрэгжүүлсэн байна.

№	Зорилт, арга хэмжээ		Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн хувиар						
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Биелэлтийн дүн
				100 %	90%	70%	50%	30%	0%	
1	ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	26	20	2	1		3		90.0%

Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, дүн хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээ, ажил үйлчилгээ байна. Үүнд:

- 2022-2024 онд хөдөөгийн сумдын 4 ерөнхий боловсролын сургуулийн бага сургууль, цэцэрлэгийн салбар, бүлэг, соёлын төвийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох зорилт тавьсан. Үүнээс Дашбалбар сумын бага сургуулийн ариун цэврийн байгууламж ашиглалтад орсон. Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөлд 2 цэцэрлэг, 3 сургууль, 1 дотуур байр хамрагдаж байна. Үүнд: Төслийн 2 дугаар ээлжийн ариун цэврийн байгууламжийн угсралтын ажил (Дорнод, Баян-Уул), 3 дугаар ээлжийн ариун цэврийн байгууламжийн угсралтын ажил (Дорнод, Сэргэлэн, Матад, Хөлөнбуйр)-ын гүйцэтгэл 60-80%-тай, 4 дүгээр ээлжийн ариун цэврийн байгууламжийн угсралтын ажил (Дорнод, Баянтүмэн) тендер зарлагдаад байгааг харгалзан тодорхой үр дүнд хүрсэн гэж үзэн 70 хувь гэж үнэлсэн.
- “Боловсролын үйлчилгээнд цахим платформыг хэрэгжүүлж, цаас, цаг хэмнэсэн шинэ системийг нэвтрүүлэн, түгээн дэлгэрүүлэх, “Инновацийн төв” байгуулна”, “Дорнод аймаг дахь их сургуулиудын хотхон байгуулахаар эхлүүлсэн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнүүдийн хүрээнд Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төв болгон хөгжүүлэх хотхоныг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж, эх загвар зураг батлуулан, хангагч байгууллагууд болон Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас зөвшөөрөл авсан. Барилгын хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлт нь бичигдсэн. Техникийн нөхцөл, зураг, төсвийн ажлыг хийж дуусгасан. Төсөв санхүүгийн

Эх сурвалж: ХЯНАЛТ-ШИНЖИЛЭЭ ҮНЭЛЭЭ ХАРИУЦСАН АХИАХ АРГА ЗҮЙЧ А.МӨНХЖАР АЛ

Email: muugii75edu@gmail.com Утас: 89336088

асуудал шийдэгдээгүй. Багш хөгжлийн ордны барилгыг 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд оруулахаар Сангийн яамны хөрөнгө оруулалтын системд бүртгүүлсэн. Газрын асуудал шийдэгдээгүй байна. 2024 онд эдгээр чиглэлээр ажил хийгдээгүй тул эрчимжүүлэх шаардлагатай гэж 30 хувиар үнэллээ.

Дүгнэлт:

Төлөвлөгөөний эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэгдсэн арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байдал нь байгууллага /Боловсролын газар/ бүрэн удирдаж чадахуйц бус арга хэмжээнүүд байна.

Зөвлөмж:

Хэрэгжиж дууссан, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон заалтуудыг хяналтаас хасуулах тухай үндэслэл бүхий саналыг холбогдох газарт хүргүүлж байх нь зүйтэй.

ДӨРӨВ.БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн хүрээнд дараах тайланг үнэлэхэд 80.6-99.1 хувийн биелэлттэй байна.

№	Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	Заалтын тоо	Хэрэгжилт						
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Биелэлтийн дүн
				100%	90%	70%	50%		
1	Боловсролын сайд болон Дорнод аймгийн Засаг даргын хооронд 2024 онд орон нутагт боловсролын салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээ	83	76	2	4			1	97.1
2	Боловсролын сайдтай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	67	63	3	1				99.1
3	Аймгийн Засаг даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	73	58	9	4	1	1		95.5
4	Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр	31	23		1	2	1	4	80.6
	БҮГД	254	220	14	10	3	2	5	95.2
5	Шилэн дансны хөтлөлт								98.6

Дүгнэлт:

Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрт тусгагдсан “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийн “Байгууллагын чиг үүргийн хүрээнд зохион байгуулж буй ажлын гүйцэтгэл, үр нөлөөг тогтмол үнэлж, удирдлагын дүн шинжилгээ хийж, үйлчилгээний чанарыг

нэмэгдүүлэх, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ”, “Төрийн албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулж, эмчилгээ, сувилал, эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох ажлыг үе шаттай зохион байгуулна” заалтуудын тайлагналт дутуу, “Албан хаагчдын хэрэгцээнд үндэслэн зохион байгуулсан сургалтын тоо зорилтот түвшинд хүрээгүй тул эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-50 хувьтай, “Аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, 2030 оныг хүртлэх төсөөлөл болон сум, байгууллагын урт, дунд хугацааны зорилтыг хангахад учирч болох эрсдэлийг тооцож, эрсдэлд суурилсан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ”, “Албан хаагчийн амьжиргааг сайжруулах, амьдралын түвшинг дээшлүүлэхэд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих, туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ”, “Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай хүртээмжтэй болгох албан хаагчдын ажлыг хөнгөвчилсэн зардал хэмнэсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ”, Эрхэлсэн ажил мэргэжлийнхээ дагуу оюуны бүтээл туурвиж буй албан хаагчдад дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилт үр дүнгүй буюу хангалтгүй байна.

Зөвлөмж:

- “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах

4.2. Боловсролын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

4.2.1. Боловсролын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны жилийн эцсийн байдлаар 99.2 хувьтай буюу “үр дүнтэй” гэж хэрэгжүүлсэн гэж өөрийн үнэлгээг хийсэн байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэснийг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт		Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн хувиар						
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүн гүй	Биелэлтийн дүн
					100 %	90%	70%	50%		
1	Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.	7	6	1					98.6
2		Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	15	14	1					99.3
3	Гурав. Хуулиар тусгайлан	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг	16	16						100

Эх сурвалж: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ АРГА ЗҮЙЧ А.МӨНХЖАРГАЛ
Email: muugii75edu@gmail.com Утас: 89336088

	олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	дэмжихэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.							
4		Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмж, нийгмийн баталгааг хангана.	10	10					100
5		Мэргэжлийн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.	4	3	1				97.5
6		Насан туршийн боловсролын суралцахуйн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг сурч хөгжих тэгш боломж олгоно.	2	2					100
7		Бүх шатны боловсролын сургалтын үйл ажиллагааг суралцагчийн хэрэгцээнд нийцсэн тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг хөнгүүлнэ.	3	3					100
8	Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Бүх шатны төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ.	6	6					100
9.	хэмжээ	Хүнд суртлаас урьдчилан сэргийлэх	5	4		1			90.0
		БҮГД	68	64	3	1			99.12

4.2.2. Гүйцэтгэлийн төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ

- ЗГХЭГ-ын 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтад заасан бүрдэл бүрэн
- Зорилт арга хэмжээ хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан. /Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд төлөвлөлтөө хийхдээ “Алсын хараа-2050”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийн хөгжүүлэх үндсэн 5 чиглэл, Монгол улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө зэрэг тухайн онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд туссан ижил нэршил, бие биеэ агуулсан утгатай зорилтуудыг нэгтгэж, нэг гүйцэтгэлийн зорилт болгон тодорхойлсон./

эх сурвалж: ХЯНАЛТ-ШИНЖИЛЭЭ, ҮНЭЛЭЭ ЭЭ ХАРИУЦСАН АХИАХ АРГА ЗҮЙЧ А.МӨНХЖАР АЛ

Email: muugii75edu@gmail.com Утас: 89336088

- Нийт төлөвлөсөн арга хэмжээ зорилттой уялдсан.
- Зорилт, арга хэмжээний төсөв, түүний эх үүсвэрийг тусгасан
- Суурь түвшний мэдээллийн найдвартай байдал сайн
- Хүрэх түвшинг хагас, бүтэн жилээр тодорхойлсон
- Зорилтын үр дүнд чиглэсэн шаардлагыг хангасан эсэх – суурь болох зорилтот түвшинг тоо болон хувиар илэрхийлсэн нь хэмжигдэхүйц байх шаардлагыг хангасан.
- Төлөвлөсөн нийт арга хэмжээг байгууллага бүрэн удирдаж чадахуйц арга хэмжээ 80,8%
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулахдаа өмнөх жилд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг тусган сайжруулсан байна.

4.2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

Боловсролын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 3 бүлэг 9 зорилтын хүрээнд 73 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 96.5 хувьтай буюу “үр дүнтэй” гэж үнэлэгдэж байна.

№	Зорилт	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн хувиар						Биелэлтийн дүн
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
			100 %	90%	70%	50%	30%	0%	
1	Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	22	16	2	4				98.6
3	Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	35	30	4	1				100
8	Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	11	10		1				100
	БҮГД	68	56	6	6				96.5

Үнэлгээ буурсан арга хэмжээнүүд:

1.1.3. Таван настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулна арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100%, ХШҮ: 70%. Үнэлгээний тайлбар: 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 100 хувь хамруулаагүй байна /зорилтот түвшинд хүрээгүй/. Тайланг товч бичсэн, хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тайлагнах

1.1.4. Цэцэрлэгийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100%, ХШҮ: 90%. Үнэлгээний тайлбар: Ялгаатай хэрэгцээтэй 50 хүүхдийг сургуулийн өмнөх

боловсролд хамруулах чиглэлээр хийсэн болон хийхээр төлөвлөж байгаа ажил тодорхойгүй байна.

1.5.1. Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 90% ХШҮ: 70%. Үнэлгээний тайлбар: Сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалт зорилтот түвшинд хүрээгүй /58 хувь/ байна.

1.2.1. Нэг багш, нэг бүлэгт ногдох хүүхдийн тоог стандарт жишигт хүргэхийн тулд цэцэрлэг, сургуулийг өргөтгөх, шинээр барих ажлыг эрчимтэй зохион байгуулна арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 70%. Үнэлгээний тайлбар: Зорилтот түвшинд хүрээгүй.

1.2.3 “Хүүхдэд ээлтэй орчин” төслийн хүрээнд хөдөөгийн сумдын ЕБС-ийн бага сургууль, цэцэрлэгийн салбар бүлгийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үргэлжлүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 90% ХШҮ: 70%. Үнэлгээний тайлбар: Зорилтот түвшинд хүрээгүй.

1.2.15. Сурах бичгийн хангалтын хувийг нэмэгдүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 90% Үнэлгээний тайлбар: Сурах бичгийн цахим хувилбарыг ашиглаж буй эсэх, худалдаж байгаа сурах бичгийн талаар тайланд тусгагдаагүй

3.1.8 Ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлээ судалж буй суралцагчдын ирц, хамрагдалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 90%. Үнэлгээний тайлбар: Ахлах ангийн 10-11 дүгээр ангийн цахим сургуульд сонгон судлах хичээлээ судалж буй суралцагчдын ирц хангалтгүй байна

3.1.13. Боловсрол, сургалтын байгууллага, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангахад хяналт тавин ажиллана арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 90%. Үнэлгээний тайлбар: Стандартыг хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар тусгагдаагүй.

3.3.3 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчийг ажлын байртай холбох ажлыг орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулна арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 90%. Үнэлгээний тайлбар: Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь зорилтот түвшинд хүрээгүй:

3.3.4. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ зохион байгуулна арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 90% ХШҮ: 70%. Үнэлгээний тайлбар: Эрэлттэй болон Тэргүүлэх чиглэлээр элсэн суралцсан суралцагчдын тоо зорилтот түвшинд хүрээгүй.

3.5.3. Өмчийн бүх хэлбэрийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ арга хэмжээний хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээ: 100% ХШҮ: 90%. Үнэлгээний тайлбар: Зөвлөн туслах ажлын үр дүнг тайланд тодорхой тусгаагүй

Зөвлөмж

Барилга байгууламж, хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газар 100 хувь бүрэн удирдан чадахуйц бус байдаг. Тодруулбал, Орон нутаг дахь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийг үндэслэн барилгын угсралтын ажлын явцад техникийн хяналт гүйцэтгэх үүргийг Барилгын хөгжлийн төвөөр гүйцэтгүүлдэг. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь захиалагчийг төлөөлж гэрээ байгуулдаг. Барилгын явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжилтийн эрх олгодог.

Тухайн арга хэмжээг гүйцэтгэгчээс хамаарч биелээгүй гэж дүгнэгдэх эрсдэлтэй байна. Иймд цаашид Барилга байгууламж, хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгахгүй байх, тусгасан тохиолдолд шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох нь зүйтэй.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ АРГА ЗҮЙЧ



А.МӨНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН: ДАРГА

Ч. АРИУНАА